

МОНГОЛ УЛСАД ЭКСПОРТЫН ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Ч.Ундрам*, М.Бага-Өрнөлт**

Хураангуй: Монгол улсад экспортын чиг баримжаатай үйлдвэрлэгч, аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих гол хөшүүргүүдийн нэг болох санхүүгийн дэд бүтцийг сайжруулах зорилгоор Олон улсад хэрэглэгддэг “экспортын кредит даатгал” (Export credit insurance)-ыг зах зээлд нэвтрүүлэх, түүнийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, амжилттай нутагшуулахын тулд экспортлогчдыг сургаж бэлтгэх цогц хөтөлбөрийн талаар энэхүү судалгаанд авч үзсэн болно.

The study contemplates on improving financial infrastructure of the country by introducing export credit insurance as a stimulus to the domestic exporters. Furthermore, to insure the well-functioning of the export credit insurance, concepts on improvement of the legal environment, train and empowerment programs for domestic exporters are proposed.

Түлхүүр үг: экспорт, экспортлогчид, экспортын кредит даатгал, даатгалын бүтээгдэхүүн, баталгаа, төлбөрийн эрсдэл.

Удиртгал

Монгол улс нь чөлөөт эдийн засагт шилжсэнээс хойш эдийн засгийн бүтцэд томоохон өөрчлөлт орж, уул уурхайн салбараас хараат болж экспортын бүтээгдэхүүний дийлэнх хувийг тус салбарын боловсруулаагүй бүтээгдэхүүн эзэлж байна. Тиймээс эдийн засгийг төрөлжүүлэх үүднээс нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжиж гадаадын зах зээл дээр өрсөлдөхүйц бүтээгдэхүүн гаргах шаардлагатай. Үүнийг төрөөс бодлогын түвшинд тогтолцоогоор нь авч үзэх нь чухал бөгөөд эцсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээгээр дээгүүр тооцогддог улс орнуудын туршлагад үндэслэж болох юм.

Экспортыг дэмжихийн тулд аж ахуйн нэгжүүдийн чадавхийг сайжруулахаас гадна санхүүгийн дэд бүтцийн тогтолцоог сайжруулах хэрэгтэй. Үндэсний бизнес эрхлэгч нарын эрэлт, хэрэгцээнд нийцсэн санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд шуурхай нэвтрүүлэх, түүнийг эрхзүйн зохицуулалтаар баталгаажуулах, хөгжүүлэх шаардлагатай байна. Энэ асуудлын хүрээнд даатгалын салбарын хөгжилд томоохон хувь нэмэр болохуйц

* МУИС-ийн Сургалтын нэгдсэн алба, (Email) undrammuis@gmail.com

** МУИС-ийн Бизнесийн сургууль, докторант


шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар судлан, хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлж, санал дэвшүүлэх нь уг судалгааны ажлын үндсэн зорилгод нийцнэ. Уг судалгаанд “экспортын кредит даатгал”-ын онол аргагүйн асуудал, манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүний өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, даатгалын салбарын бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог, эрхзүйн зохицуулалт, “экспортын кредит даатгал”-ыг нэвтрүүлсний ач холбогдлын талаар авч үзэн дүгнэлт хийсэн болно.

1. Экспортын кредит даатгал (export credit insurance)

Экспортын кредит даатгал нь “Trade credit insurance” нэршлээр 19-р зуунд Баруун Европын орнуудад Дэлхийн 1 болон 2-р дайны үед хийгдэж байсан худалдааны эрсдэлийг бууруулах зорилгоор Засгийн газрын бодлогоор бий болжээ.

Энэ үед дайнаас үүдэн эдийн засаг хүндэрч худалдаачид зээлээр бизнес хийх шаардлага ч өндөр болж тэднийг улсаас дэмжих шаардлага урган гарч, зарим улс энэ чиглэлийн үйл ажиллагааг эрхэлдэг төрийн байгууллагатай болсон байна. 1991 онд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Экспортын төлбөрийн баталгааны газрын нэг хэсэг буюу Богино хугацааны зээлийн баталгаа хариуцсан хэсгийг хувьчилснаар энэхүү санхүүгийн бүтээгдэхүүн илүү хөгжиж өнөөдөр тус чиглэлийн хамгийн том тоглогчид нь Euler Hermes, Atradius компаниуд болоод байна.

Зураг 1.



Экспортын кредит даатгалын үндсэн зорилго нь бизнесүүдийн хооронд худалдааг илүү хялбар, харилцан ашигтай болгох явдал юм. Компани борлуулж

буй бүтээгдэхүүн, үйлчилгээгээ худалдан авагч компанидаа богино хугацааны зээллэг хэлбэрээр буюу кредитээр олгоход үүнийг эрсдэлгүй болгох баталгааг “кредит даатгал” гэнэ. Ийм төрлийн эрсдэлийг олон улсын зах зээл дээр бизнес эрхэлж байгаа үед бууруулах нь чухал байдаг. “Зээллэг”-ээр буюу кредитээр зарсан барааны төлбөр төлөгдөхгүй байх эрсдэл худалдан авагчаас өөрөөс нь эсвэл гадны шалтгаанаас үүдэж болно. Жишээлбэл худалдан авагч санхүүгийн хүндрэлд орох, байгалийн давагдашгүй хүчин зүйлсээс үүдэн төлбөрөө хугацаанд нь төлөх боломжгүй болох гэх мэт тохиолдлоуд байдаг.

Экспортын кредит даатгалтай болсноор компаниуд үйлчлүүлэгчээсээ төлбөр хүлээн авахтай холбоотой эрсдэлээс зайлсхийж, өр барагдуулахад зарцуулах цаг хугацаа, мөнгө хөрөнгө, бухимдалаа багасгах давуу талтай. Үйлчлүүлэгчид банкнаас зээл авч төлбөр төлөхийн оронд илүү бага зардалтай, харьцангуй чирэгдэл багатай даатгалын бүтээгдэхүүнийг сонгох боломжтой болох тул тэдний бизнест ч үр өгөөжтэй, мөн нөгөө талаас борлуулт хийж буй талын эрэлт ч нэмэгдэх магадлал өндөртэй бүтээгдэхүүн юм.

Энэ санхүүгийн бүтээгдэхүүн нь бие биенээ мэдэхгүй, өөр өөр улс орны эрх зүйн орчинд үйл ажиллагаа явуулж буй компаниудын хооронд итгэлцэл бий болгоход ашиглагддаг байна. Гадны компаниудын хувьд бараа хүлээн авсан хойноо, эсвэл бүтээгдэхүүнийг цааш нь худалдан борлуулсны дараа төлбөрөө төлөх баталгаатай нөхцөлтэйгөөр хамтарч ажиллах боломж бүрддэг. Ингэж аж ахуйн нэгжүүд экспорт хийхдээ гадны компаниас төлбөрөө уян хатан нөхцөлтэйгээр авах нь санхүүгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг байна.

2. Монгол улсын гадаад худалдааны өнөөгийн байдал

Манай улс өнгөрсөн 2016 оны байдлаар дэлхийн 152 орноос 3357.9 сая ам.долларын бараа, бүтээгдэхүүн импортлосон ба энэ нь өмнөх 2015 оноос 11.6 хувиар буурсан үзүүлэлт юм. Эдгээр бараа бүтээгдэхүүний гарал үүслийг улс орнуудаар нь ангилан үзвэл ОХУ-аас 26.2 хувь, БНХАУ-аас 31.0 хувь, АНУ-аас 4.1 хувь, Япон улсаас 9.8 хувь, БНСУ-аас 5.9 хувь, ХБНГУ-аас 3.6 хувь ногдож байгаа нь нийт импортын 80.6 хувийг эзлэж байна.³


Мөн хугацаанд дэлхийн 74 оронд 4917.3 сая ам.долларын бараа, түүхий эд экспортлосноос БНХАУ-д 79.0 хувь, Их британид 11.3 хувь, Швейцар-д 4.7 хувь буюу нийт экспортын 91.4 хувийг эдгээр орнуудад гаргасан байна. 2016 онд эрдэс бүтээгдэхүүний экспортын 97.5 хувийг чулуун нүүрс, зэсийн

³ <http://customs.gov.mn>, Статистикийн мэдээлэл, 2016 он, МУ-ын Гаалийн Ерөнхий Газар

баяжмал, молибдены баяжмал, хайлуур жонш, төмрийн хүдэр, цайрын хүдэр болон боловсруулаагүй нефтийн экспорт эзэлж байна. 2016 онд чулуун нүүрсний 98.5 хувийг БНХАУ-руу гаргасан байна. 2015 онтой харьцуулахад зэсийн баяжмалын экспорт 84.2 мянган тонноор өссөн ч, хилийн дундаж үнэ нь 513.7 ам.доллараар, үнийн дүн нь 672.5 сая ам.доллараар тус тус буурчээ. 2015 онд зэсийн баяжмалыг 100.0 хувь БНХАУ-д гаргасан байна.⁴

Монгол улсын эдийн засаг уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай байна. Сүүлийн 3 жилийн (2014 -2016 он) статистик үзүүлэлтийн дунджаар нийт экспортын 88 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, 8 хувийг мал аж ахуйн гаралтай түүхий эд, анхан шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн, 4 хувийг дунд, эцсийн шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн эзэлж байгаа бөгөөд нийт экспортын 86 хувийг БНХАУ руу гаргаж байна.


Зураг 2.



Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл, 2014-2016 он,
Үндэсний статистикийн хороо

⁴ <http://customs.gov.mn>, Статистикийн мэдээлэл, 2016 он, МУ-ын Гаалийн Ерөнхий Газар

Зураг 3.



*Эх сурвалж: Статистикийн мэдээлэл,
2014-2016 он, Гаалийн ерөнхий газар*

2015 онд 1020 аж ахуйн нэгж, иргэн бараа, бүтээгдэхүүн экспортод гаргасны 162 (давхардсан тоогоор 173) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэл эрхлэгч бөгөөд үүний 100 нь эцсийн шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн экспортод гаргасан байна⁵. Энэ нь Монгол улс экспортыг хөгжүүлэхэд нэгдүгээрт, эдийн засгийг төрөлжүүлж олон нэр төрлийн өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хоёрдугаарт, БНХАУ-аас бусад улс орнуудтай хийх гадаад худалдааг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

3. Монгол улсын даатгалын салбарын өнөөгийн байдал

Манай улсад 2016 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 40, даатгалын хохирол үнэлэгч 29 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Мөн даатгалын компанийн 252 салбар, 10 төлөөлөгчийн газар, даатгалын зуучлагч компанийн 208 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 51 салбар, 2 төлөөлөгчийн газар Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.⁶

⁵ Статистикийн эмхэтгэл, 2014-2016 он, Үндэсний статистикийн хороо


⁶ Санхүүгийн зохицуулах хороо, Даатгалын салбарын 2016 оны III улирлын танилцуулга

Хүснэгт 1. Даатгалын зах зээл дээрх
тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

№	Мэргэжлийн оролцогчид	2012	2013	2014	2015	2016-III
1	Ердийн даатгалын компани	17	16	16	15	15
2	Урт хугацааны даатгалын компани	1	1	1	1	1
3	Давхар даатгалын компани				1	1
4	Даатгалын төлөөлөгч	2357	3187	3260	3340	3020
5	Даатгалын зуучлагч	17	20	30	37	40
6	Даатгалын хохирол үнэлэгч	9	14	20	27	29
7	Актуарч	18	15	15	15	15
8	Даатгалын үйл ажиллагаанд аудит хийх эрх бүхий аудитын компани					41
9	Аудитор					124
	Бүгд	2419	3253	3244	3436	3286

*Эх сурвалж: Даатгалын салбарын 2016 оны
III улирлын танилцуулга, СЗХ*

Зураг 4.



Даатгалын компаниудын нийт хөрөнгө, түүний өсөлт

Даатгалын хураамжийн нийт орлогын бүтцэд хөрөнгийн даатгал 30.3 хувь, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 25.2 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 12.8 хувь, гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал 10.4 хувийг эзэлж, 21.3 хувь нь бусад даатгалын хэлбэрт ногдож байна.

Хүснэгт 2. Даатгалын хэлбэр ба хураамжийн нийт орлого

№	Даатгалын хэлбэр	Даатгалын нийт хураамжийн орлого		Өсөлт, бууралт / хувиар/
		2015.III	2016.III	
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	8,465.68	9,270.25	9.5%
2	Хөрөнгийн даатгал	20,999.37	26,886.18	28.0%
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	11,922.63	11,352.79	-4.8%
4	Ачааны даатгал	1,069.29	1,405.74	31.5%
5	Барилга угсралтын даатгал	439.31	1,845.17	320.0%
6	Газар тариалангийн даатгал	0	13.70	100.0%
7	Мал амьтдын даатгал	478.32	669.89	40.0%
8	Агаарын хөлгийн даатгал	2,819.79	2,525.11	-10.5%
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	282.03	313.08	11.0%
10	Хариуцлагын даатгал	4,798.82	5,018.60	4.6%
11	Санхүүгийн даатгал	2,728.67	2,682.53	-1.7%
12	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	17,998.66	22,354.50	24.2%
13	Эзэлийн даатгал	577.78	637.13	10.3%
14	Итгэлцлийн даатгал	12.85	279.28	2073.9%
15	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	15,204.88	2,604.44	-82.9%
16	Хугацаат амьдралын даатгал	271.74	115.15	-57.6%
17	Насан туршийн даатгал	0	0	
18	Хуримтгалын даатгал	63.09	60.56	-4.0%
19	Тэтгэврийн даатгал	39.60	40.21	1.6%
20	Эрүүл мэндийн даатгал	931.37	712.93	-23.5%
	Дүн	89,103.87	88,787.25	-23.5%

Эх сурвалж: Даатгалын салбарын 2016 оны III улирлын танилцуулга, СЗХ

4. Экспортыг дэмжих төрийн бодлого, хэрэгжилт

Засгийн газар тогтвортой эдийн засгийг дэмжих зорилгоор зам, дэд бүтэц, барилгын салбаруудыг үе шаттайгаар дэмжиж ирсэн боловч уул уурхайн салбараас хараат байдал буурахгүй байна. Үүний шалтгаан нь эдийн засгийн төрөлжилтийн дутмаг байдал, экспортын чиг баримжаатай уул уурхайн бус салбарын хөгжлийн хоцрогдол юм.

Эдийн засгийн бүтцийг өргөжүүлэх, экспортын төрлийг нэмэгдүүлэх чиглэлд Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоол Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг баталсан бөгөөд уг бодлогын баримт бичигт мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл зэрэг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гадаад зах зээлийг тэлэх, экспортыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр бодлого баримталж, хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 жилийн дундаж өсөлтийг 2025 онд 20 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн байна.

Мөн Улсын Их Хурлаас 2015 оны 62 дугаар тогтоолоор Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг баталж уг бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2016 оны 211 дүгээр тогтоолоор Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр (2016-2020 он)-ийг баталсан. Уг хөтөлбөрт экспортын орлогыг нэмэгдүүлж, бүтцийг төрөлжүүлэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд буюу уг хөтөлбөрийн 3.1.3.т “экспортын даатгалын тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах”, санхүүжилтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд буюу хөтөлбөрийн 3.3.3.т “экспортлогчдыг гадаад худалдааны эрсдэлээс хамгаалах зорилгоор экспортын баталгаа гаргах, даатгалын үйл ажиллагааг нэвтрүүлэх” асуудлуудыг тус тус тусгасан байна.

2010 оноос хэрэгжиж эхэлсэн Монгол Улс, Япон Улсын хоорондын “стратегийн түншлэл”-ийн хүрээнд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг 2015 онд байгуулсан бөгөөд цаашид бүс нутгийн чөлөөт худалдааг өргөжүүлэх чиглэлээр бусад улс орнуудтай гэрээ хэлэлцээрүүдийг хийхээр ажиллаж байна. Гэвч эдгээр бодлогын баримт бичиг, гэрээ хэлэлцээр хийгдсэнээс хойш манай улсын гадаад худалдаа, тэр дундаа экспортын чиглэлд төдийлөн ахиц, амжилт гарахгүй байгаа нь түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн дэд бүтэц хөгжөөгүй, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн чадавхи сул байгаатай холбоотой юм.

Монгол улсын нийт аж ахуйн нэгжийн 95 хувь нь жижиг, дунд бизнес эрхлэгчид байдаг бөгөөд эдгээр нь улсын нийт ажлын байрны 50 хувийг бий болгож ДНБ-ийн 40 хувийг бүрдүүлэх боловч улсын төсвийн 2 орчим хувийг л бүрдүүлдэг байна. Жижиг дунд бизнес эрхлэгчдийн хөгжилд эх үүсвэрийн өндөр өртөг, татварын дарамт, зардлын өсөлт, зах зээлийн шингээлтийн хүрэлцээгүй байдал, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны сул уялдаа, мэдээллийн хүртээмжгүй байдал зэрэг сул талууд чөдөр тушаа болсоор байгаагаас хөгжих бололцоо бага байна.

5. Монгол улсад экспортын даатгалыг хөгжүүлэх асуудал

Экспортын кредит даатгалын бүтээгдэхүүн одоогоор манай улсад нэвтэрч хэрэгжээгүй байна. Экспортыг дэмжих санхүүгийн бүтээгдэхүүн бий болгох, хөгжүүлэхэд эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай. Экспортын кредит даатгалыг бий болгосноор Монгол улсын экспортыг бодитоор дэмжих бөгөөд үүнийг нэвтрүүлэхдээ Засгийн газраас тодорхой үе шаттайгаар системийн хувьд шийдвэрлэх шаардлагатай.

Даатгалын тухай хууль тогтоомжийн хүрээнд энэ чиглэлийн бүтээгдэхүүн үйлчилгээг зээл буюу баталгаа гаргах хэлбэрт хамруулан авч үзэх талтай бөгөөд одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа уг хуульд зааснаар даатгалын нөөц сангаас аливаа хэлбэрийн зээл, зээлийн баталгаа гаргахыг хориглодог. Иймд уг харилцааг даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах замаар нэр, нэршлийг тодорхой болгож, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл ангилалаар зах зээлд нэвтрүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх нь зүйтэй. Мөн экспорт хийхээр зорьж буй үндэсний компаниудад экспортын кредит даатгал, баталгаа олгох санхүүгийн бүтээгдэхүүнийг санал болгож хөгжүүлэх үйл ажиллагааг эрхлэн явуулах компанийг төрөөс байгуулах, эсвэл одоо байгаа улсын даатгалын тогтолцоо буюу “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг чадавхижуулах, санхүүжүүлэх боломж бас байна.

Дээрх бүтээгдэхүүн, үйлчилгээний гол онцлог нь гадаад худалдан авагчийн төлбөрийн эрсдэлийг давхар даатгалын бүтээгдэхүүнээр хамгаалах хэлбэр бөгөөд харилцагчийн судалгаа, мэдээлэл, баталгаа нилээд шаардах учраас одоогийн түвшинд шууд нэвтрүүлэхэд манай дотоодын ердийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын нөхөн төлбөр олгох, эрсдэл даах чадварт сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай. Иймд эхний ээлжинд давхар даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий компаниудад уг даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, турших байдлаар эхлүүлэх нь оновчтой болно.

Манай улсын жижиг дунд бизнес эрхлэгчдийн дийлэнх нь импортлогчид тул гадаад худалдааны санхүүжилтэд түгээмэл ашигладаг хэлбэр болох арилжааны банкуудын эх үүсвэртэй ба эх үүсвэргүй төлбөрийн баталгаа гаргуулах аккредитивын аргыг голчлон ашиглаж байна. Цаашид экспортын чиг баримжаатай дотоодын жижиг дунд үйлдвэрлэлийг түлхүү дэмжихийн тулд санхүүгийн дэд бүтцийг сайжруулж, гадаад худалдан авагч талуудын түгээмэл хэрэглэдэг “нээлттэй данс” (open account)-аар бараа бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд гаргах шаардлага тулгараад байна. Энэ асуудлаар Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2015 оны 9 дүгээр сард Жижиг дунд үйлдвэрлэгч нарын дунд явуулсан судалгаагаар бараа бүтээгдэхүүн экспортлоход төлбөрийн

сайн нөхцөл, арга хэлбэр санал болгосон экспортлогч тал гадаад зах зээл дээр давуу байдал эзэмшиж байгаа талаар дурдсан нь харгалзан үзвэл зохих өрсөлдөөний томоохон чухал хүчин зүйлсийн нэг болохыг харуулж байна.

Экспортын чиг баримжаатай аж ахуйн нэгжүүдийг дэмжихэд шаардлагатай санхүүгийн дэд бүтцийн хууль, эрхзүй орчинг бий болгох, институцийн тогтолцоог бүрдүүлэх нь гол суурь нөхцөл бөгөөд үүний үндсэн дээр дараах чиглэлээр нэмэлт дэмжлэг үзүүлж ажиллах шаардлагатай. Үүнд:

- Бүс нутгийн хэмжээний томоохон худалдааны хэлэлцээрүүдийг тодорхой үе шаттай байгуулж, чиглэсэн тодорхой зорилгот зах зээлүүдэд дотоодын экспортлогч аж ахуйн нэгжүүд нэвтрэх боломжийг нээх.
- Дотоодын аж ахуйн нэгжүүдийг экспорт хийх чиглэлээр чадавхижуулж тэдний өрсөлдөх чадварыг сайжруулах, нэмүү өртөг шингэсэн, гадаадын зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангаж өрсөлдөхүйц бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор сургах, зөвлөгөө, консалтинг өгөх.
- Гадаад худалдааны чиглэлээр судалгааны ажлыг дэмжих, монгол улсыг төлөөлөн гадаад худалдааны гэрээ, хэлэлцээр хийж буй мэргэжилтнүүдийг сургах.
- Эдгээр компаниудад ажиллах ирээдүйн боловсрон хүчнийг бэлтгэх зорилгоор гадаад худалдааны мэргэжилтэн бэлтгэдэг Их дээд сургуулиудын боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг сайжруулах.

Гадаад зах зээлд өрсөлдөхөд бүтээгдэхүүний чанараас гадна санхүүгийн нөхцөл чухал байдаг. Экспортын кредит даатгал нь дараах давуу талуудыг экспортлогчдод бий болгодог. Үүнд:

- Экспортлогч нь ирээдүйд худалдан авагчаас орох мөнгөн урсгалаа баталгаажуулна. Хэрэв худалдан авагч ямар нэгэн эрсдэлд орж төлбөр төлөх бололцоогүй болбол түүний төлбөрийн үлдэгдэлийг даатгалын байгууллага төлнө гэсэн үг юм. Энэ нь экспортлогчийн бизнесийн ирээдүйн мөнгөн урсгалыг хамгаалах боломжтой болгох юм.
- Даатгалын байгууллагын мэдээлэл, шинжилгээнд тулгуурлан найдвартай худалдан авагчтай харилцах боломжтой. Мэдээллийн баазыг өргөжүүлж, харилцагчийг найдвартай эсэх талаарх мэдээллээр баяжуулахад туслана.

- Экспортлогчийн үйлдвэрлэлээ өргөжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, зээллэгийг нэмэлт барьцаалбаргүй олгох боломж олгодог. Энэ нь ЖДҮ-ийн өнөөгийн уламжлалт санхүүжилтийн хэлбэр болох барьцаа хөрөнгийн дутмаг байдлаас үүдсэн хүндрэлийг даван туулахад дэмжлэг болно.

Дүгнэлт

Монгол улс нь чөлөөт эдийн засагт шилжсэнээс хойш эдийн засгийн бүтэц өөрчлөгдөж, экспортийн дийлэнх хувийг БНХАУ руу экспортолсон уул уурхайн салбарын боловсруулаагүй бүтээгдэхүүн эзэлж байна. Энэ байдал нь манай улсын эдийн засгийг гадаад зах зээл дээрх түүхий эдийн үнэ ханш болон нэг улсын гадаад бодлогоос хамааралтай, эмзэг цочромтгой болгож байна.

Засгийн газар тогтвортой эдийн засгийг дэмжих зорилгоор зам, дэд бүтэц, барилгын салбаруудыг үе шаттайгаар дэмжиж ирсэн боловч уул уурхайн салбараас хараат байдал буурахгүй байна. Үүний шалтгаан нь эдийн засгийн төрөлжилтийн дутмаг байдал, экспортын чиг баримжаатай уул уурхайн бус салбарын хөгжлийн хоцрогдол бөгөөд эдийн засгийг төрөлжүүлэх үүднээс үйлдвэрлэгч, аж ахуй нэгжийн нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг тасралтгүй тууштай дэмжиж, гадаад зах зээлд өрсөлдөхүйц бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох шаардлагатай.

Экспортыг дэмжих бодлогын хүрээнд аж ахуйн нэгжүүдийн чадавхийг сайжруулахаас гадна санхүүгийн дэд бүтцийн тогтолцоог сайжруулах, үүний тулд үндэсний бизнес эрхлэгчдийн эрэлтэд нийцсэн санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, эрхзүйн орчныг бүрдүүлэх, энэ чиглэлээр Олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтарч ажиллах хэрэгтэй байна.

Олон улсын санхүүгийн зах зээлд экспортлогч орнуудад түхлүү санал болгодог бүтээгдэхүүн бол “экспортын кредит даатгал” юм. Энэ бүтээгдэхүүний үндсэн зорилго нь бизнесүүдийн хооронд худалдааг илүү хялбар болгож, төлбөрийн эрсдэлээс хамгаалан харилцан ашигтай болгох явдал юм. Компани борлуулж буй бүтээгдэхүүн, үйлчилгээгээ худалдан авагч компанидаа кредитээр олгоход түүний төлбөрийг эрсдэлгүй болгох баталгааг “кредит даатгал” гэдэг. Кредит даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Олон улсад танигдсан томоохон даатгалын байгууллагууд нь олон жилийн мэдээлэл, судалгаан дээр үндэслэн уг бүтээгдэхүүнийг хөгжүүлж, улам боловсронгуй болгосоор байна.

Экспортын кредит даатгалын бүтээгдэхүүн одоогоор манай улсад нэвтэрч

хэрэгжээгүй тул энэ бүтээгдэхүүнийг бий болгох, эрхлэх явуулах институцийг тодорхойлж, эрхзүйн орчныг бүрдүүлэх, даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид, зуучлагчдыг татан оролцуулах, дотоодын бизнес эрхлэгчдийг сургах, мэдлэг, мэдээллээр хангах, их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийн агуулгад энэ чиглэлийн асуудлыг тусгаж, хөгжүүлэх шаардлага бий болоод байна.

Экспортын кредит даатгалыг бий болгосноор Монгол улсын экспортыг бодитоор дэмжих бөгөөд экспортлогчийн бизнесийн ирээдүйн мөнгөн урсгалыг хамгаалах, даатгалын байгууллагын мэдээлэл, шинжилгээнд тулгуурлан найдвартай худалдан авагчтай харилцах, экспортлогчид үйлдвэрлэлээ өргөжүүлж, бүтээгдэхүүнээ хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт авахад баталгаа болох зэрэг томоохон давуу талууд бий болох юм.

Ашигласан материал

1. Даатгалын тухай хууль
2. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль
3. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль
4. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль
5. Компанийн тухай хууль
6. УИХ, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, 2015 он
7. УИХ, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, 2015 он
8. МУ-ын ЗГ, Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр, 2016 он
9. ОУСК, Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйчүүдийн судалгаа, 2015 он
10. Хөдөлмөрийн яам, Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгаа, 2014 он
11. Үндэсний хөгжлийн хүрээлэн, Монгол улсын хөгжлийн судалгаа, 2012 он
12. Үндэсний статистикийн хороо, Статистикийн эмхэтгэл, 2014, 2015, 2016 он
13. Гаалийн ерөнхий газар, Статистикийн мэдээлэл, 2014, 2015, 2016 он